# ХАРХОРИН СУМЫН 2 ДУГААР БАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ Б.САРАНГЭРЭЛИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрэх түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **ЗОРИЛТ НЭГ.**"БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ТУСГАЙЛСАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД. | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ №1.1. Хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах | -Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тоо | - | Хууль тогтоомжийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна. | Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангагдсан. | 2025.01.02-2025.06.06 | 90% |
| | Арга хэмжээ №1.2. Татвар, төлбөр хураамж, бусад орлого бүрдүүлэлтийг төвлөрүүлэх / | -Орлогын биелэлтийн хувь. | - | 40% | Малын тоо толгойн албан татвар 5,082,750 төгрөгийг төвлөрүүлсэн байна.<br><br>Нохойн албан татвар 150,000 төгрөгийг бүрдүүлсэн. | 2025.01.02-2025.06.06 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| 2 | Арга хэмжээ №1.3. Багийн мэдээллийн самбарын мэдээллийг тогтмол шинэчлэх, сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулах | -Албан тушаалтанд шаардлагатай мэдээ мэдээлэл хүргэсэн эсэх<br><br>-Сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулсан тоогоор | - | Иргэд болон холбогдох байгууллагууд, албан тушаалтанд шаардлагатай мэдээ мэдээлэл хүргэсэн байна. | Мэдээллийн самбарын мэдээллийг тогтмол шинэчлэн иргэдэд цаг үеийн мэдээ мэдээллийг өгч түргэн шуурхай ажилласан.<br><br>Иргэд болон сурагчдын дунд тулгамдаж буй асуудлын хүрээнд брошур бэлтгэн тараасан. Хамтарсан багийн үйл ажиллагааны хүрээнд хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлын хэсэг гарган аюулгүй байдлыг хангах чиглэлээр 5 сарын 21-нд Татварын тасгийн дарга Дэлгэрмаа, хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан Ш.Болормаа, Б.Нинждулам, багийн Зохион байгуулагч Б.Сарангэрэл гэсэн бүрэлдэхүүнтэйгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Зочид буудал, нийтийн халуун усны газарт хягалт шалгалт таьж ажилласан. Мөн 6 сарын 4-ны өдөр 6-р багийн Засаг дарга Л.Төгөлдөр, Нийгмийн бодлогын мэргэжилтэн А.Цэрэнчимэд, Эрүүлжүүлэх | 2025.01.02-2025.06.06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | саатуулах байрны цагдаа дэд ахлагч Х.Дагийранз нартай хамтран эргүүлийн үүрэг гүйцэтгэж 3 сургуулийн дотуур байр, тоглоомын газар, байнгын архидан согтуурдаг айл өрхөөр орж хүүхдийн эрх зөрчигдсөх асуудлын хүрээнд хяналт тавьж ажилласан. | | |
| 3 | Арга хэмжээ №1.4. Захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог хангах, багийн иргэдийн нийтийн хурлын бэлтгэлийг хангах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх | -Шийдвэр гаргалтад тусгагдсан иргэдийн саналын тоогоор | - | Шийдвэр гаргалтад иргэдийн санал тусах нөхцөл, оролцоо нэмэгдсэн байна. | Багийн иргэдийн нийтийн хуралд 135 өрхийн 143 иргэний төлөөлөл ирснээр 60 хувийн ирцтэй багийн иргэд оролцсон.<br>Ирцийн бүртгэл болон бэлтгэл ажлыг хангах, хуралдааны тэмдэглэлийг хугацаанд албажуулан ИТХ-ын ажлын албанд хүргэж ажилласан.<br>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналыг 178 иргэнээс цаасаар авч бүртгэлийн хуудаст гарын үсэг зуруулж баталгаажуулсан.<br>Иргэд шийдвэр гаргах, санал бодлоо илэрхийлэх нөхцөл боломжоор хангагдан оролцсон. | 2025.02.02 | 90% |
| 4 | Арга хэмжээ №1.5. Цэргийн тоо бүртгэл болон цэрэг татлагын ажилд иргэдийг бүрэн хамруулж, | -Цэргийн албанд тэнцсэн залуучуудын тоогоор | - | 1.1 Цэргийн албанд тэнцсэн залуучуудын тоогоор | 1.1. 2025 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг 01 сарын 06-аас 18-ны өдрийг хүртэл 18-50 насны цэргийн бэлтгэл үүрэгтэн, 55 хүртлэх насны бэлтгэл офицер, ахлагч, | 2025.01.06-2025.01.18,<br>2025.04.29 | 89% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах | -Мөнгөн төлбөр төлсөн иргэдийн тоогоор<br>-Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлд 18-50 насны эрчүүдийг бүрэн хамруулсан тоо | | 1.2 Мөнгөн төлбөр төлсөн иргэдийн тоогоор<br>1.3 Хуулийн хэрэгжилт хангагдсан байна | 60 хүртлэх насны бэлтгэл офицер, 65 хүртлэх насны бэлтгэл дээд офицеруудыг бүртгэж ажилласан.<br>2025 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлага 4 дүгээр сарын 29-ны өдөр явагдсан. Ганган Орхон багийн цэргийн насны 82 иргэнд зарлан дуудах мэдэгдэл өгч цэрэг татлагын комиссоор 89 хувьтай оролцуулсан.<br>1.2. Мөнгөн төлбөр төлөх 2 иргэнд нэхэмжлэлийг өгсөн.<br>1.3. Цэргийн албыг дүйцүүлэн биеэр хаах 3 иргэний материалыг бүрдүүлэн сумын цэргийн штабт хүлээлгэн өгсөн. | | |
| 5 | Арга хэмжээ №1.6. Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээний ажилд байгууллага, аж ахуй нэгж, иргэдийг идэвхитэй оролцуулах | Орчны аюулгүй байдал сайжирсан эсэх | - | Холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран орчны аюултай байдлын хор уршигийг таниулах ажил зохион байгуулсан байна. | 2025 оны 04 дүгээр сарын 25, 26-ны өдрүүдэд нийтийн хог цэвэрлэгээнд багийн иргэдийг идэвхтэй хамруулж ажилласан.<br>Хөгшин Орхон голын ай сав газрыг онцгой хамгаалалтын бүс дэх хог хаягдлыг 05 дугаар сарын 09-ны өдөр цугларсан амьтны сэг зэм, хог хаягдлыг 300 гаруй албан хаагчтай хамт түүж цэвэрлэсэн. | 2025.04.26, 2025.05.09 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Арга хэмжээ №1.7. Гамшгаас хамгаалах хуулийг айл өрхөд сурталчлах, иргэдэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллагатай хамтарч санамж, зөвлөгөө өгөх | -Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулсан тоогоор<br><br>-Иргэдэд чанартай мэдээлэл хүргэсэн эсэх | - | - Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулсан байна.<br>-Зөвлөмж, мэдээллийг тухай бүр өгч холбогдох байгууллагатай хамтран ажилласан байна. | Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, шадар сайдын ажлын алба, онцгой байдлын ерөнхий газартай хамтран стратегийн команд штабын дадлага сургуулийг 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрүүдэд зохион байгуулан гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуулийн сургалтуудад онцгой комисст бэлтгэл ажлыг хангаж ажилласан. | 2025.03.27 | 100% |
| **ЗОРИЛТ ХОЁР.** "БАГИЙН ӨРХ, ХҮН АМЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ЗОХИХ ЖУРМЫН ДАГУУ НЭГТГЭН МЭДЭЭЛЖ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАН, УДИРДЛАГЫГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ, ТАЙЛАГНАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭ/ *Албан тушаалын зорилго,.зорилтод суурилсан ТЖАХ-ийн гүйцэтгэлийн зорилт /* | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ №2.1. Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн праграмыг тогтмол баяжуулж, иргэний түр оршин суух бүртгэлийг хөтлөх. | ХАӨМСангийн алдааг тухай бүр засаж, баяжилт хийгдсэн тоогоор | - | ХАӨМСангийн алдааг тухай бүр засч баяжилт хийсэн байна. | Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн праграмыг тогтмол баяжуулж, алдааг засаж, иргэний түр оршин суух бүртгэлийг хөтөлж ажиллаж байна. | 2025.01.02-2025.06.06 | 100% |
| 2 | Арга хэмжээ №2.2. Завсрын болон түүвэр тооллогыг хууль журмын дагуу нутаг дэвсгэртээ зохион байгуулах, төрийн байгууллага, | Тооллогыг чанартай зохион байгуулсан эсэх | - | Цаг хугацаанд нь, чанартай хийж гүйцэтгэх<br><br>Төл бойжилт, зүй бус хорогдол, тариалалтын мэдээ системд шивсэн байна. | Хадлан тэжээлийн мэдээ 1 удаа, тариа хураалт-1 удаа, үнийн мэдээ 1 удаа системд шивж оруулсан байна. | 2025.01.02-2025.06.06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангах | | | | | | |
| 3 | Арга хэмжээ №2.3. Багийн иргэдийн бүртгэл судалгааг нарийвчлан цахим болон бусад хэлбэрээр гаргаж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах | Мэдээллийн сан бүрдсэн байна. | - | Багийн иргэдийн бүртгэл судалгааг нарийвчлан гаргасан байна. | Ургац тариалалт, хураалт, үнийн мэдээг цаг бүрт цахим системд шивсэн.<br>Автотээврийн шинэчилсэн бүртгэл, тооллого хийж багийн иргэдийг бүрэн хамруулан ажилласан.<br>2025 оны суурь судалгаа буюу нийгмийн зарим үзүүлэлт судалгааны хүрээнд 12 төрлийн судалгаа гаргасан.<br>Тойрогт хамрагдах 4-6 настай хүүхдүүдийн судалгааг цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулиудад гарган өгсөн.<br>Боловсролын судалгаа буюу 6-18 настай хүүхдүүдийн эцэг эхийн боловсрол болон сургууль завсардсан хүүхдүүдийн судалгааг гарган өгсөн.<br>Ургийн бичиг хөтөлдөг иргэдийн судалгааг гарган холбогдох мэргэжилтэнд гарган өгсөн.<br>80-аас дээш настны судалгааг гарган улсын бүртгэлд гарган өгсөн. | 2025.01.02-2025.06.06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Алдарт эхийн 1, 2 дугаар одон авах 18 иргэний материалыг бүрдүүлж холбогдох мэргэжилтэнд өгсөн.<br>Том малын зүй бус хорогдлын мэдээ, шар усны үер болон халиа, түшинд өртөх эрсдэлтэй айл өрхийн судалгаа, байнгын асаргаа болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, иргэдийн судалгааг холбогдох мэргэжилтэнд гарган өгсөн.<br>308 өрхөөс агаарын бохирдлын талаарх судалгааг авч байгаль орчны хяналтын Улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт өгсөн.<br>Багийн ганц бие залуучуудын судалгааг нийгмийн бодлогын мэргэжилтэнд гарган өгсөн.<br>Сум дундын Цагдаагийн хэлтсээс албан мэдэгдэлийн хариуг цаг хугацаанд нь үнэн зөв гарган холбогдох байгууллагатай уялдаа холбоотой ажилласан. | | |
| **ЗОРИЛТ ГУРАВ.** ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ №3.1. Төлөвлөгөө, тайлан, ажлын байрны | Төлөвлөгөө гарган тайланг тогтоосон хугацаанд | - | 1.1. Төлөвлөгөө, тайлан, ажлын байрны тодорхойлолтод | Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг тогтоосон хугацаанд гарган өгч ажилласан. | 2025.01.02-2025.06.06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тодорхойлолтод заасан чиг үүрэгт хамаарах хууль, тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилтийн тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргах | тайлагнасан эсэх. | | заасан чиг үүрэгт хамаарах хууль, тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнасан байна. | | | |
| 2 | Арга хэмжээ № 3.2. Ажлын байрны үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, холбогдох мэдээллээр хангах | Ажлын байрны үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, холбогдох мэдээллээр хангасан эсэх | - | Мэдээллээр бүрэн хангагдсан байна. | Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас зохион байгуулсан түр ажлын байранд давхардсан тоогоор 14 иргэнийг жуулчлан ажиллуулсан. | 2025.01.02-2025.06.06 | 100% |
| 3 | Арга хэмжээ №3.3. Байгууллагаас зохион байгуулсан цаг үеийн холбогдолтой, нэмэлт үйл ажиллагаанд идэвхтэй оролцох | Байгуулагаас зохион байгуулсан цаг үеийн холбогдолтой, нэмэлт үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон эсэх | - | Байгуулагаас зохион байгуулсан цаг үеийн холбогдолтой, нэмэлт үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон байна. | Байгууллагаас зохион байгуулагдсан дотоод сургалтуудад бүрэн хамрагдсан.<br>Сургалтанд хамрагдсанаар харилцаа хандлагаа сайжруулж, багаар ажиллах чадвар, харилцааны ур чадвараа дээшлүүлж үг хандлагаа ажилдаа мөрдлөгө болгон ажиллаж байна. | 2025.01.02-2025.06.06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Арга хэмжээ № 3.4. Төрийн албаны тухай хууль болон төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрэм журам, байгууллагын дотоод журам, бусад төрийн албаны стандартыг мөрдөж хэрэгжүүлэх | Төрийн албаны тухай хууль болон бусад стандарт дүрэм, журмыг зөрчөөгүйг нотлох дүгнэлт гаргасан тоогоор | - | Төрийн албаны тухай хууль болон бусад стандарт дүрэм, журмыг чандлан мөрдсөн байна. | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөн ажиллаж, ёс зүйн зөрчил гаргаагүй болно. | 2025.01.02-2025.06.06 | 100% |
| 5 | Арга хэмжээ №3.5. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид урьдчилан сэргийлэх тухай болон Авлигын эсрэг хууль тогтоомжийг мөрдөх, хэрэгжилтийг хангах | Авилга хувийн ашиг сонирхлын зөрчил гаргахгүй ажилласан эсэх. | - | Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх | Авилга ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан болно. | 2025.01.02-2025.06.06 | 100% |
| 6 | Арга хэмжээ №3.6. Архив, албан хэрэг | 1.1.Албан хэрэг хөтлөлтийн | - | 1.1.Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын | 1.1. Албан хэрэг хөтлөлтийн стандарт нийтлэг журмыг мөрдлөг болгон ажилласан. | 2025.01.02-2025.06.06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн баримт бичгийн гаргаж, өргөдөл гомдолд хариу өгөх, архивын нэгж бүрдүүлэх | нийтлэг журмын сургалтад хамрагдсан байна.<br>1.2.Хугацаанд нь шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоогоор<br>1.3.Авилга хувийн ашиг сонирхлын зөрчил гаргахгүй ажилласан эсэх. | | сургалтад бие даан хамрагдсан байна.<br>1.2.Иргэдийн өргөдөл гомдол, ирүүлсэн төслийг хугацаанд нь шийдвэрлэж тухай бүрт нь хариуг нь мэдэгдэж ажилласан байна.<br>1.3.Авилга хувийн ашиг сонирхлын зөрчил гаргахгүй ажилласан байна. | 1.2. Иргэдээс ирсэн өргөдөл, гомдол байхгүй.<br>1.3. Авилга, ашиг сонирхол ёс зүйн зөрчилгүй ажиллаж байна. | | |
| **ЗОРИЛТ ДӨРӨВ**. "СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНООС ӨГСӨН УДИРДАМЖ, ЧИГЛЭЛИЙН ДАГУУ СТАТИСТИКИЙН ТООЛЛОГО, ТҮҮВЭР СУДАЛГААГ ЗОХИОН БАЙГУУЛНА" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ №4.1. Албан ёсны статистик мэдээ, тайланг графикийн дагуу үнэн зөв цуглуулах, хугацаанд нь программд оруулж буй эсэхэд хяналт тавьж ажиллах | -Графикт мэдээний тоо, чанар<br>-Программд хугацаанд нь шивсэн эсэх | - | -Графикт мэдээний тоо, чанар<br>-Программд хугацаанд нь шивсэн эсэх | Тариалалтын мэдээг цуглуулж, хугацаанд нь программд шивж оруулсан. | 2025.01.02-2025.06.06 | 100% |
| 2 | Арга хэмжээ №4.2. Хүн ам, өрхийн мэдээллийн санг | Хүн ам, өрхийн мэдээллийн | - | Сумын хүн ам, өрхийн мэдээллийн | Шинэ төрсөн хүүхэд, нас баралтыг бүртгэж, өрхийн алдаатай иргэдийн алдааг | 2025.01.02-2025.06.06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үнэн зөв хөтөлж, тогтмол баяжилт хийх | санд засвар, өөрчлөлт хийсэн тоо | | санд баяжилт хийж, шинээр төрсөн хүүхдийн мэдээллийг нэмж, нас барсан хүний мэдээллийг хассан байна. | засаж ХӨАМС бүртгэж, баяжилт хийж ажилласан<br><br>Байршлын цэг хатгах, шилжилт өрх баталгаажуулах, Статусын газраас ирсэн УБЕГ нас барсан ҮСХ нас бараагүй, ҮСХ-нд нас барсан УБЕГ нас бараагүй, хүчингүй төлөвтэй, харьяатаас гарсан, одоо байгаа зэрэг иргэдийн мэдээллийн ХӨАМС хянаж, тодруулгыг явуулсан болно. | | |
| 3 | Арга хэмжээ №4.3. Хагас, бүтэн жилийн мал тооллогын ажлыг хариуцлагатайгаар зохион байгуулж, дүнг мэдээллийн санд хугацаанд нь үнэн зөв оруулах | Тооллогыг хугацаанд нь зохион байгуулсан байдал<br><br>-Тооллогын мэдээллийг программд үнэн зөв оруулсан эсэх | - | Хугацаанд нь чанартай сайн хийж гүйцэтгэсэн байна | Хагас жилийн малын түүвэр тооллогыг 2025 оны 06 дугаар сарын 4-өөс эхлэн зохион байгуулагдаж багийн 21 малчны нэрс иржж айл өрхөөр бүрээр орж малын тооллого хийж байна. | 2025.01.02-2025.06.06 | 100% |

**ЗОРИЛТ ТАВ**. НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-НЫ БИЕЛЭЛТ

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрэх түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Арга хэмжээ № 5.1 Амьжиргааны түвшин тогтоох судалгаа | - | 300 өрх | 248 | Түүвэрчилсэн судалгаар ирсэн 248 өрхийн мэдээллийг системд шивж айл болгоноор орж асуумжийг бөглөсөн. | 2025.02.07 | 100% |
| 2 | Арга хэмжээ № 5.2 XVII жарны "Элдэв Эрдэнэт" хэмээх хөхөгчин модон могой жилийн босгон дээр төрийн дээд одон медаль болон Засгийн газрын шагналаар шагнагдсан иргэдийн шагналыг гардуулах | - | - | - | Төрийн дээд одон медаль болон Засгийн газрын шагналаар шагнагдсан иргэдийн шагналыг гардуулах арга хэмжээнд ажлын хэсэгт орж ажилласан | 2025.02.26 | 100% |
| 3 | Арга хэмжээ № 5.3 Бүх нийтийн хог цэвэрлэгээ | Байгууллагаас зохион байгуулсан ажилд идэвхтэй оролцсон байх | - | - | Эрдэнэтолгой багийн Арцат 2-4 гудамжны айлуудаар явж мэдээлэл хүргэсэн бөгөөд давхар хяналтын хэсэгт орж ажилласан. | 2025.04.26 | 100% |
| 4 | Арга хэмжээ № 5.4 Мод тарилтын үйл ажиллагаа | Байгууллагаас зохион байгуулсан ажилд идэвхтэй оролцсон байх | - | - | Тэрбум мод үндэсний хөдөлгөөн бүх нийтийн мод тарих үндэсний өдрүүдийн хүрээнд Хүүхдийн паркад нөхөн тарилт хийсэн. | 2025.05.07 | 100% |
| 5 | Арга хэмжээ № 5.5 Өвөрхангай аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөлөөс зохион байгуулагдах | - | Байгууллагын албан хаагчид бүгд оролцох | Байгууллагын албан хаагчид бүгд оролцох | Төрийн албан хаагчдын үндэсний бичиг мэдлэг, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор албан хаагчдаас шалгалт авч | 2025.05.23 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үндэсний бичгийн сорил | | | | материалыг битүүмжлэн аймаг руу явуулсан | | |
| 6 | Арга хэмжээ № 5.6 “Эхийн алдар” одон гардуулах үйл ажиллагаа | Байгууллагаас зохион байгуулсан ажилд идэвхтэй оролцсон байх | - | - | “Эхийн алдар” одон гардуулах үйл ажиллагаа зохион байгуулах ажлыг хэсэгт ажилласан. | 2025.05.30 | 100% |
| 7 | Арга хэмжээ № 5.7 Эх үрсийн баярыг тохиолдуулан байгууллагын хүүхдүүдийг хүлээн авах арга хэмжээ | Байгууллагаас зохион байгуулсан ажилд идэвхтэй оролцсон байх | - | - | Эх үрсийн баярыг тохиолдуулан байгууллагын хүүхдүүдийг хүлээн авах ажлын хэсэгт ажилласан. | 2025.05.31 | 100% |
| 8 | Арга хэмжээ №5.8 Эх үрсийн баярын арга хэмжээ | Байгууллагаас зохион байгуулсан ажилд идэвхтэй оролцсон байх | - | - | Дугуй уралдаанд оролцох хүүхдүүдийг бүртгэж уралдахад аюулгүй байдлыг шалгаж ажилласан. | 2025.06.01 | 100% |
| 9 | Арга хэмжээ №5.9 Хангай хайрханы тахилга | Байгууллагаас зохион байгуулсан ажилд идэвхтэй оролцсон байх | - | - | Хангай хайрхан тахилгын ажлын хэсэгт орж ажилласан. | 2025.06.04 | 100% |
| 10 | Арга хэмжээ №5.10 “Эрсдэлгүй Өвөрхангай” аппликейшн | | - | - | “Эрсдэлгүй Өвөрхангай” аппликейшнд бүртгэгдсэн мэдээллийг шийдвэрлэсэн. | 2025.06.04 | |

## ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрэх түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | Монгол бичгийн түвшинг ахиулах сургалт хөтөлбөрт хамрагдах, бие даан суралцах | -Монгол бичгийн сургалтанд хамрагдсан<br>-Бие даан судалсан байдал | - | Монгол бичгийн түвшинг 25 хувиар өссөн байна. | Сумын хэлний мэдлэгийн зөвлөлөөс "Өглөөний уншлага аян"-ыг эхлүүлэн байгууллагын алба хаагчдад 7 хоногийн 3 дахь өдөр өглөөний уншлагыг хийж байгаатай холбоотойгоор монгол хэлний мэдлэгээ бататган унших, бичих, сонсох чадвараа дээшлүүлэн ажилласан. | 01.05-06.06 | 100% |
| 2 | Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн Пүрэв гарагт цахим хэлбэрээр 7:4:10 арга зүйн сургалтуудыг судлах | -7:4:10 арга зүйн сургалтуудыг судалсан эсэх | - | ТАЗ-н сайтад байршигдсан сургалтуудыг судлан мэдлэг чадвараа дэшлүүлсэн байна. | Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн Пүрэв гарагт цахим хэлбэрээр 7:4:10 арга зүйн сургалтад 5 удаа хамрагдсан. | 01.02-06.06 | 100% |
| 3 | Хэрэглээний программуудын мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэх | -Өдөр дутмын үйл ажиллагаандаа | - | Өдөр тутмын хэрэглээний программыг ашиглах, | Excel, Word, Power point зэрэг өдөр тутмын хэрэглээний программ болон хүснэгтэн мэдээлэл хийх, график хийх зэрэг мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор | 01.02-06.06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ашигласан байдал | | чадвар нэмэгдсэн байна | цахим хичээл үзэж мэдлэгээ дээшлүүлж байна. | | |

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН БИЧСЭН:

2 ДУГААР БАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ (Албан тушаалын нэр)

Б.САРАНГЭРЭЛ................................ (Нэр гарын үсэг)

2025 оны 6 сарын 9 өдөр (Он сар өдөр)